


*Эрдмийн хэт цахиваас
Хөгжлийн гал бадартой*



МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ ЭЛСЭЛТ 2017



МУИС-ийн ТАНИЛЦУУЛГА

Монгол улсын ууган их сургууль (МУИС) нь 1942 онд байгуулагдсан байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухаан, инженерчлэл, хууль, эрх зүй, бизнесийн удирдлага, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын хөтөлбөрүүд бүхий бүрэлдэхүүн 5 сургууль, орон нутаг дахь харьяаллын 2 сургууль, үндэсний статустай 3 хүрээлэн, судалгааны нэгжүүдтэй, бакалавр, магистр, докторын сургалттай, либерал боловсрол (liberal art education) олгодог цогцолбор (comprehensive) судалгааны их сургууль юм.

АЛСЫН ХАРАА

Дэлхийн стандартад нийцсэн, Монгол улсын хөгжил дэвшлийн тулгуур болсон үндэсний загвар судалгааны их сургууль байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Байгаль, нийгэм, хүмүүнлэгийн болон технологийн салбарт шинэ мэдлэг бүтээж, түгээн дэлгэрүүлдэг, тогтвортой хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний хөгжлийн үзэл баримтлал бүхий үндэсний их сургууль байж, улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулна.

УРИА

“Эрдмийн хэт цахиваас Хөгжлийн гал бадармой”
МУИС-ийн ОЮУТАН МОНГОЛЫН ИРЭЭДҮЙ”

ҮНЭТ ЗҮЙЛС

1. Академик эрх чөлөө
2. Сонголт ба өрсөлдөөн
3. Сайн засаглал
4. Нийгмийн хариуцлага
5. Уламжлал ба шинэчлэл

МУИС-ийн ЭЛСЭЛТ 2017

ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ

МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрийн элсэлтийн бүртгэл орон даяар <http://burtgel.num.edu.mn> хаягаар явагдана. Өмнөх оны төгсөгчид 2017 оны 05 дугаар сарын 01-нээс, Энэ оны төгсөгчид 06 дугаар сарын 01-нээс 07 дугаар сарын 03-ны 18:00 цаг хүртэл бүртгүүлнэ үү. Элсэх хүсэлт гаргагч нь элсэлтийн системд Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээрээ нэвтэрч бүрэлдэхүүн/салбар сургуулиа сонгож бүртгүүлнэ.

Бүртгүүлэгч нь хэдэн ч бүрэлдэхүүн/салбар сургуульд бүртгүүлж болох ба бүртгэлийн хураамжийг онлайнаар болон paybill хэлбэрээр төлж бүртгэлээ баталгаажуулна.

ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ

Элсэлтийн систем бүртгэл хааснаас 1 өдрийн дараа бүртгүүлэгч бүрээр холбогдох тооцооллыг хийн онооны жагсаалтыг бүрэлдэхүүн/салбар сургуулиар гаргана. Хяналтын тоонд багтсан тохиолдолд элсэлтийн системээс бүртгүүлэгчид мэдэгдэнэ.

Зөвхөн элсэлтийн бүртгэлийн системд элсэх хүсэлт гаргасан, БСШУСЯ-наас тогтоосон босго оноо хангасан бүртгүүлэгчдийг жагсаана.

ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

Элсэх эрх олгох үйл ажиллагаа орон даяар <http://burtgel.num.edu.mn> хаягаар явах ба хяналтын тоонд багтсан элсэх хүсэлт гаргагч 24 цагийн дотор элссэн сургуулийн 1 багц цагийн төлбөрийг онлайнаар болон paybill хэлбэрээр төлж элсэх эрхээ баталгаажуулна.

Хэд хэдэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг бүрэлдэхүүн/салбар сургуулийг сонгох ба тодорхой нэг хөтөлбөр сонгож элсэхгүй, бүрэлдэхүүн сургууль/салбарт элсэнэ.

ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

Элсэгчид нь 2017 оны 08 дугаар сарын 08-наас 08 дугаар сарын 25-ны хооронд ажлын цагаар холбогдох бичиг баримтыг бүрдүүлэн бүрэлдэхүүн/салбар сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр ирж бүртгүүлнэ. Ирэхдээ <http://burtgel.num.edu.mn> хаягаар нэвтэрч бүртгэлийн цахим маягт бөглөсөн.

- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрт) хамт;
- Танилцаж баталгаажуулсан МУИС-д суралцах гэрээ (Элсэлтийн системээс татаж авах);
- Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг, хуулбарын хамт);
- ЭЕШ-ын батламж, хуулбарын хамт;
- Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхийн шаардлагад нийцсэн цээж зураг файлаар (сүүлийн 3 сард авахуулсан) бүрдүүлэн эдгээр бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛИЙН ОНООГООР ЖАГСААХ ЖАГСААЛТ, ОНООНЫ ХАРЬЦАА

БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛЬ (60%, 40%-р тооцон жагсаах)	ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ	
	“Суурь” шалгалт (60%)	“Дагалдах” шалгалт (40%)
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ, БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	- Биологи - Газарзүй - Математик - Физик - Хими	- Англи хэл - Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Физик - Хими
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ, НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	- Математик - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг	- Англи хэл - Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Монголын түүх - Орос хэл - Физик - Хими
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ, ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР	- Англи хэл - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл	- Англи хэл - Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл - Физик - Хими
ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	- Биологи - Математик - Физик - Хими	- Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Физик - Хими
ХҮҮЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	Нийгмийн тухай мэдлэг	Математик
ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	- Англи хэл - Орос хэл - Монголын түүх	- Математик - Монгол хэл - Нийгмийн тухай мэдлэг

БҮРЭЛДЭХҮҮН/САЛБАР СУРГУУЛЬ (80%, 20%-р тооцон жагсаах)		“Суурь” шалгалт (80%)	“Дагалдах” шалгалт (20%)
БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	Математик		- Англи хэл - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл
ЗАВХАН СУРГУУЛЬ	- Англи хэл - Биологи - Математик - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл - Физик - Хими		- Англи хэл - Биологи - Газарзүй - Математик - Монгол хэл - Монголын түүх - Нийгмийн тухай мэдлэг - Орос хэл - Физик - Хими
ОРХОН СУРГУУЛЬ		- Англи хэл 100 - Математик 100 - Монгол хэл 100 - Орос хэл 100	

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬД ЭЛСЭН СУРАЛЦСАНААР

- Үндсэн мэргэжлээ сонгон суралцахын зэрэгцээ Хос болон хавсарга мэргэжлээр давхар суралцах боломжтой.
- Суурь шалгалтад тооцуулсан байгалийн ухааны ЭЕШ нь 750-аас дээш оноотой ШУС-БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч /сургууль тус бүрт 25/ мөн Математик, Физик, Хими, Биологи, Техник технологи, Мэдээлэл зүйн улсын олимпиадад 1-ээс 3-р байр эзэлж элссэн бол сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.
- ШУС, ХШУИС-ийн оюутан гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт/honors/ хамрагдах боломжтой.
- ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын аль ч хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой.
- МУИС-ийн ерөнхий суурийн зарим хичээлийг англи хэл дээр судлах боломжтой.



Суурь шалгалтад тооцуулсан байгалийн ухааны ЭЕШ нь 750-аас дээш оноотой ШУС-БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч /сургууль тус бүрт 25/, улсын олимпиадад 1-ээс 3-р эзэлж элссэн бол сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө.



Үндсэн мэргэжлээ сонгон суралцахын зэрэгцээ Хос болон хавсарга мэргэжлээр давхар суралцах боломжтой.



ШУС, ХШУИС-ийн оюутан гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт/honors/ хамрагдах боломжтой.



ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын аль ч хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой.



МУИС-ийн ерөнхий суурийн зарим хичээлийг англи хэл дээр судлах боломжтой.



ОЛИМПИАД

БСШУСЯ-аас тогтоосон олон улсын болон улсын олимпиадын төгсгөлийн шатанд сүүлийн 2 жилийн дотор оролцож байр эзэлсэн ерөнхий боловсролын сургууль төгсөгчийг тухайн чиглэлээр олимпиад зохион байгуулах комиссоос олгосон батламж болон дипломыг үндэслэн шууд элсүүлнэ.

Олимпиад нөхцлөөр элсэгч 2017 оны 06 дугаар сарын 19-30-ны хооронд ажлын цагаар холбогдох бичиг баримтын эх хувь болон хуулбарын хамт Сургалтын нэгдсэн албанд авчирна.

№	Бүрэлдэхүүн сургууль/салбар	Олимпиадын чиглэл	Эзэлсэн байр
1	Шинжлэх ухааны сургууль- Байгалийн ухааны салбар	- Биологи - Газарзүй - Математик - Физик - Хими	I-VI
2	Шинжлэх ухааны сургууль- Нийгмийн ухааны салбар	- Математик - Нийгмийн Ухаан - Түүх	I-III
3	Шинжлэх ухааны сургууль- Хүмүүнлэгийн ухааны салбар	- Англи хэл - Монгол хэл - Орос хэл - Түүх - Хятад хэл	I-III
4	Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	- Биологи - Газарзүй - Математик - Физик - Хими	I-VI
5	Бизнесийн сургууль	Математик	I-VI
6	Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	- Англи хэл - Орос хэл	I-III
7	Хууль зүйн сургууль	Нийгмийн ухаан	I-III
8	Завхан сургууль	- Англи хэл - Математик - Нийгмийн ухаан - Орос хэл - Физик	I-VI

ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ

МУИС-д байгаль, нийгэм, хүмүүнлэгийн суурь шинжлэх ухааны салбаруудын хөгжиж ирсэн уламжлал, эрдмийн чадавхи туршлагад тулгуурлан, дэлхийн тэргүүлэх их сургуулиудын загвар, хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн Шинжлэх Ухааны Сургуулийг байгуулсан юм.

Тус сургууль нь шинжлэх ухааны суурь чиглэлүүдээр сургалт, судалгааны ажил эрхлэн явуулж, Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухаан хэмээх 3 салбар, мэргэжлийн 19 тэнхимд 470 гаруй багш, 90 орчим ажилтан, бакалаврын түвшний 9200 гаруй оюутан, ахисан түвшний 1900 гаруй суралцагч, бакалаврын 64 хөтөлбөр, магистр, докторын 44 хөтөлбөрөөр сургалтын үйл ажиллагаа явуулж байна.

Байгалийн ухааны салбар: Математик, Физик, Хими, Биологи, Газарзүй, Геологи-геофизик зэрэг мэргэжлийн 6 тэнхимтэй. Шинжлэх ухааны эдгээр чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг чиг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэж, бакалаврын болон ахисан түвшний шаталсан сургалт явуулж улс орны хөгжилд далайцтай хувь нэмэр оруулах, үндэсний сургалт судалгааны төв байх эрхэм зорилготойгоор ажиллаж байна.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Багш, байгалийн ухааны боловсрол / Хими, Биологи, Физик, Газарзүйн багш/
- Багш, математикийн боловсрол /Математикийн багш/
- Байгаль орчныг зайнаас тандан судлал
- Биологи
- Биологийн нөөц судлал
- Биохими
- Биотехнологи
- Газарзүй
- Газар зохион байгуулалт
- Геологи
- Геофизик
- Математик
- Физик
- Хими
- Хот ба бүс нутгийн төлөвлөлт
- Экологи



Нийгмийн ухааны салбар: Антропологи-археологи, боловсрол сэтгэл судлал, эдийн засаг, улс төр судлал, социологи-нийгмийн ажил, сэтгүүл зүй олон нийтийн харилцааны 6 тэнхимтэй. Хөтөлбөрүүд нь уян хатан, сонголт ихтэй, оюутны чадвар чадавхийг нээж хөгжүүлэх, сурах эрх чөлөөг хүндэтгэх зарчмыг баримталдаг.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Антропологи
- Археологи
- Нийгмийн ажил
- Социологи
- Сэтгүүлзүй
- Сэтгэл судлал
- Улс төр судлал
- Эдийн засаг

Хүмүүнлэгийн ухааны салбар: Философи-шашин судлал, Түүх, Монгол хэл-хэл шинжлэл, Утга зохиол-урлаг судлал, Их Британи-Америк судлал, Европ судлал, Ази судлалын тэнхимүүд болон Гадаад хэлний сургалтын төв харьяалагддаг. Тус сургуульд хэрэгжиж байгаа хөтөлбөрүүд нь уян хатан, оюутны суралцах чадвар, сурах эрх чөлөөг хангахуйц сонголттой байдлаар боловсрогдсон байдаг.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Багш, гадаад хэлний боловсрол/Англи, Орос хэлний багш/
- Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол
- Багш, нийгмийн ухааны боловсрол / Түүхийн багш/
- Гадаад хэлний орчуулга/Англи, Орос, Солонгос, Хятад, Япон, Араб, Турк/
- Олон улс, орон судлал/Их-Британи, Америк, Хятад, Япон,
- Солонгос, Турк, Араб, Итали, Испани,
- Франц, Польш, Чех/
- Түүх
- Урлаг судлал
- Утга зохиол судлал
- Философи
- Хэл, уран зохиол /Монгол хэл, уран зохиол, Гадаад хэл, уран зохиол/
- Хэл шинжлэл /Монгол хэл шинжлэл, Гадаад хэл шинжлэл/
- Шашин судлал



ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ

Хэрэглээний Шинжлэх Ухаан, Инженерчлэлийн Сургууль (ХШУИС) нь МУИС-ийн бүтцийн өөрчлөлтийн дагуу МУИС-ийн хуучин бүрэлдэхүүн болох МТС, МКС, ГГС, ББС, ХХИС, ФЭС гэх мэт салбар сургуулиудаас инженер-технологи, хэрэглээний шинжлэх ухааны чиглэлтэй сургалтын хөтөлбөр, судлаач багш нар, оюутнуудыг нэгтгэн шинэчлэн байгуулагдсан.

Тус сургууль шинжлэх ухааныг техникийн болон нийгмийн олон салбарт хэрэглэх мэдлэг оюуны үндсэн цөм, тэргүүлэгч байж техник, технологи ба нийгмийн өмнө тулгамдсан асуудлыг шинжлэх ухаанчаар шийдвэрлэх, нийгэмдээ үйлчлэх, улс орны хөгжилд дорвитой хувь нэмрээ оруулах, иргэний өндөр ухамсар, соёлтой шилдэг мэргэжилтнүүдийг бэлтгэх зорилго тавин ажиллаж байна. Мөн гадаадын тэргүүлэх их дээд сургуулиуд болон эрдмийн зэрэг цолтой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн профессор багш нараар хичээл заалган судалгаа шинжилгээний ажил дагалдан хийх боломжтой.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Байгаль орчныг хамгаалах технологи
- Био-инженерчлэл
- Компьютерийн сүлжээ
- Компьютерийн ухаан
- Материал судлал
- Мэдээллийн систем
- Мэдээллийн технологи
- Нано шинжлэх ухаан, инженерчлэл
- Ойн үйлдвэрлэлийн техник, технологи
- Программ хангамж
- Статистик
- Сэргээгдэх эрчим хүч
- Ус судлал
- Химийн инженерчлэл
- Холбооны технологи
- Хүрээлэн буй орчин судлал
- Хэрэглээний математик
- Хэрэглээний хими
- Цаг уур
- Цөмийн инженерчлэл
- Электрон системийн автоматжуулалт



БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

Бизнесийн сургууль нь их сургуулийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд хуучин Эдийн засгийн сургууль, Худалдааны сургуулиудын үндэс суурин дээр байгуулагдсан. Бизнесийн удирдлагын чиглэлээр олон улсын хөгжлийн нийтлэг хандлагад нийцсэн эрдэм шинжилгээ, сургалтын үйл ажиллагаа явуулж, даяаршиж буй дэлхийд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэхэд оршино.

Олон улсын ACBSP байгууллагаар магадлан итгэмжлэгдсэн Санхүү, банк, даатгал, нягтлан бодох бүртгэл, менежмент, маркетинг, худалдаа, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ зэрэг бизнесийн удирдлагын хөтөлбөрүүдээс сонгон суралцаж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дипломтой төгсөх боломжтой.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Аялал жуулчлалын менежмент
- Бизнесийн удирдлага
- Даатгал
- Зочлох үйлчилгээ
- Маркетинг
- Менежмент
- Нягтлан бодох бүртгэл
- Санхүү, банк
- Худалдаа



ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ

МУИС-ийн Хууль Зүйн сургууль нь эх орондоо дээд боловсролтой хуульчдыг анх бэлтгэсэн үе үеийн эрх зүйчдийн эрдмийн өлгий билээ. Эдүгээ тус сургууль нь дээд боловсролтой эрх зүйчдийг бэлтгэх, хууль зүйн шинжлэх ухааны дотоодод төдийгүй гадаадад хүлээн зөвшөөрөгдсөн сургууль болон өсөн бэхжсэн байна.

Хууль зүйн эрдэм судлал, сургалтын талбарт үндэсний тэргүүлэх төв байж, нийгэмд манлайлах чадвартай, хууль, шударга ёсны төлөө үнэнч ажиллах, мэргэжлийн өндөр ур чадвартай, ёс зүйтэй эрх зүйчдийг бэлтгэхэд оршино.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Эрх зүй



ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ


Олон Улсын Харилцаа, Нийтийн Удирдлагын Сургууль нь олон улсын харилцаа, нийтийн удирдлагын чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлаараа үндэсний цөм байж, дэлхийн жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулж, судалгаанд суурилсан мэдлэгтэй, улс эх орныхоо эрх ашгийг олон улсын хэмжээнд хамгаалах, иргэн төвтэй засаглалыг хэрэгжүүлэх, нийгэмд манлайлах чадвартай мэргэжилтэн бэлтгэдэг, салбартаа тэргүүлэх сургууль байхад оршино.

Монгол улсын гадаад бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх, олон улсын харилцааны нөхцөл байдалд дүн шинжилгээ, үнэлэлт дүгнэлт өгч чадахуйц мэдлэг чадвартай, олон улсын улс төр, эдийн засаг, эрх зүйн харилцааны чиглэлээр мэргэшсэн, гадаад хэлний өндөр мэдлэгтэй, төрийн болон төрийн бус байгууллагуудын гадаад харилцааны салбарт ажиллах чадвар дадал эзэмшсэн олон улсын харилцааны мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн гол агуулга чиглэгдэж байна.

Монгол Улсын нийгэм, эдийн засагт нийтийн удирдлага төр, төрийн бус байгууллага, төр ба хувийн хэвшлийн түншлэл, олон нийтийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг ихээхэн өссөөр байгаа хэдий ч нийгэм, хууль эрх зүй, удирдахуйн ухаанд суурилсан чадварлаг мэргэжилтэн системтэйгээр бэлтгэх сургалтын тогтолцоог сайжруулах шаардлага тулгарч буй тул нийтийн удирдлагын чадварлаг мэргэжилтэн бэлтгэхэд хөтөлбөрийн агуулга чиглэгдэж байна.

Мэргэжлийн хөтөлбөр:

- Олон улсын харилцаа



- Нийтийн удирдлага



ОРХОН СУРГУУЛЬ

МУИС-ийн Орхон сургууль нь Эрдэнэт хотын анхны магадлан итгэмжлэгдсэн төрийн өмчийн их сургууль бөгөөд Хангайн бүсийн Сургалт-судалгаа, Багшийн хөгжлийн төв болон үйл ажиллагаагаа улам бүр өргөжүүлэн тэлсээр байна. Бидний эрхэм зорилго нь нийгэм, хүмүүнлэгийн чиглэлээр олон улсын чиг хандлагад нийцсэн, зах зээлд өрсөлдөх чадвартай мэргэжилтэн бэлтгэх явдал юм.

Мэргэжлийн хөтөлбөрүүд:

- Багш, гадаад хэлний боловсрол/англи хэлний багш, орос хэлний багш/
- Гадаад хэлний орчуулга /англи хэлний орчуулагч, хятад хэлний орчуулагч, япон хэлний орчуулагч/
- Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол /монгол хэл-уран зохиолын багш/
- Даатгал
- Маркетинг
- Менежмент
- Нягтлан бодох бүртгэл
- Санхүү, банк



ЗАВХАН СУРГУУЛЬ

МУИС-ийн Завхан сургууль нь баруун бүс нутагт сургалтын үйл ажиллагааг явуулж, Монголын баруун бүсийн аймгуудыг “Бизнесийн удирдлага”-ын мэргэжилтэй боловсон хүчнээр хангахад шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг магадлан итгэмжлэлд орсон сургууль юм.

Эрдэм шинжилгээ судалгааны ажлыг гүнзгийрүүлэх, үр дүнг нь практикт нэвтрүүлэх, Монгол улсыг бүсчлэн хөгжүүлэх төр засгийн бодлогыг баруун бүс нутагт хэрэгжүүлэхэд чиглэгдсэн сургалт, эрдэм шинжилгээ судалгааны шинэ зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Мэргэжлийн хөтөлбөрүүд:

- Нягтлан бодох бүртгэл
- Маркетинг
- Менежмент
- Худалдаа
- Бичиг хэрэг, оффисийн ажилтан
- Электрон системийн автоматжуулалт
- Багш, гадаад хэлний боловсрол
- Санхүү, банк



ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ, ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭ

1. Чиглүүлэх, зөвлөх, үйлчилгээ

МУИС-д шинээр элсэгчдэд зориулан сургалтын орчин нөхцөл болон холбогдох дүрэм журам, оюутныг дэмжих үйлчилгээ, хичээл сонголт, Сиси сургалтын систем түүний хэрэглээ, эмнэлэг, номын сангийн үйлчилгээ, оюутны байгууллага, клубүүдийн үйл ажиллагааг зөвлөн чиглүүлэх үйлчилгээгээр хүргэдэг.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

Оюутны албанаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд чадавхжуулах сургалт, ажил олгогчдын үзэсгэлэн яармаг, мэргэжил сурталчлах, томоохон ажил олгогч байгууллагуудтай танилцах аялал мөн цагийн ажилд зуучлах ажлыг зохион байгуулдаг.

3. Дотуур байр, орон суушны үйлчилгээ

МУИС нь Оюутны 6 дотуур байртай бөгөөд гадаадын 180, дотоодын 1400 гаруй оюутан хүлээн авах хүчин чадалтай. Оюутан байранд амьдрах хүсэлт гаргахдаа Сиси мэдээллийн системд нэвтрэн бүртгүүлнэ. Оюутны байранд бүртгүүлэх, оршин суухтай холбоотой зөвлөгөө, мэдээллийг МУИС-ийн албан ёсны цахим хуудсууд, оюутанд зориулсан мэдээллийн самбарт байршуулах бөгөөд “Элсэгчдэд зориулсан чиглүүлэх үйл ажиллагаа”-ны үеэр болон оюутны албанаас мэдээлэл, зөвлөгөө авах боломжтой. Чиглүүлэх үйл ажиллагаа нь хичээл эхлэхийн өмнөх 7 хоногийн турш зохион байгуулагдана.

4. Тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг

А.Тэтгэлэг: МУИС-д суралцаж буй бакалавр, магистр, докторын түвшний суралцагсдын сурч боловсрох, судалгаа шинжилгээний ажил хийж гүйцэтгэх, өөрийгөө хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, амжилттай суралцаж буй суралцагчийг урамшуулах, шилдэг элсэгчдийг дэмжих зорилгоор тэтгэлэг олгодог.

Элсэгчдийг дэмжих тэтгэлэг:

Дараах элсэгчдийн эхний хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50 хувь хөнгөлнө. Үүнд:

- Улсын олимпиадад эхний байр эзэлсэн бол;
- Суурь шалгалтад тооцуулсан байгалийн ухааны ЭЕШ нь 750-аас дээш оноотой ШУС-БУС, ХШУИС-ийн эхний 50 элсэгч / сургууль тус бүрт 25/ мөн Математик, Физик, Хими, Биологи, Техник технологи, Мэдээлэл зүйн улсын олимпиадад 1-ээс 3-р байранд шалгарч дээрх сургуулиудад элссэн бол;
- Суурь шалгалтад тооцуулсан байгалийн ухааны ЭЕШ-нд 650 болон түүнээс дээш оноотой Байгаль Эх лицей ахлах сургуулийн төгсөгч ШУС-ийн БУС, ХШУИС-д элссэн бол;

Амжилттай суралцагчдыг дэмжих тэтгэлэг:

- МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг
- Гадаад, дотоодын хувь хүн, байгууллага, сангийн нэрэмжит тэтгэлэг
- Оюутны солилцооны тэтгэлэгт хөтөлбөрүүд
- Засгийн газар, Боловсролын сангийн зээлээр гадаадад суралцах

МУИС-ИЙН СУРАЛЦАГЧДАД ЗОРИУЛСАН ТЭТГЭЛЭГ

Тэтгэлгийн нэр		тэтгэлэг зарлагдах хугацаа /сараар/									
		1	2	3	4	5	6	9	10	11	12
1	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэг										
2	Монгол Улсын Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг										
3	МУИС-ийн нэрэмжит тэтгэлэг										
4	МУИС-ийн Эрдмийн Зөвлөлийн нэрэмжит тэтгэлэг										
5	Тайваний иргэн Өнө Уртагийн тэтгэлэг										
6	Япон улсын “Сумитомо” корпорацийн нэрэмжит тэтгэлэг										
7	Япон улсын Мицубиши Корпорацийн нэрэмжит тэтгэлэг										
8	Японы Мицубиши UFJ сангийн нэрэмжит тэтгэлэг										
9	БНСУ-ын “POSCO ASIA FELLOWSHIP” – ийн тэтгэлэг										
10	Тайваний Монгол-Төвдийн хорооны тэтгэлэгт										
11	БНСУ-ын Дун-Ин форумын нэрэмжит тэтгэлэгт хөтөлбөр										
12	Хятад судлалын хөтөлбөрийн суралцагчдад зориулсан тэтгэлэг /Күнзийн институтын санаачилгын тэтгэлэг										
13	“Монгол-Намъянжу боловсролыг дэмжих сан”-ийн тэтгэлэг										



Б.САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ

- Оюутны хөгжлийн зээл: Монгол улсын их сургууль ХААН банк, Төрийн банк, Голомт банк, Хас банкуудтай гэрээ байгуулан оюутны хөгжлийн зээл олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. Боловсролын зээлийн сангийн гурван төрлийн зээлийг оюутнууд өөрсдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн авах боломжтой. Үүнд: Хүү бууруулах зээл, Богино хугацаатай зээл, Урт хугацаатай зээлийн төрлөөс сонгох юм.
- Сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж: Монгол улсын дээд боловсролын сургалтын байгууллагын дараах суралцагчдад сургалтын төлбөрийн буцалтгүй тусламж олгоно. Үүнд:
 - Бүтэн өнчин суралцагч
 - Хөгжлийн бэрхшээлтэй эсхүл эцэг, эх нь хоёулаа хөгжлийн бэрхшээлтэй бакалаврын хөтөлбөрийн суралцагч
 - Хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан гишүүнтэй өрхийн бакалаврын хөтөлбөрийн нэг суралцагч
 - Багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуульд багш мэргэжлээр элсэгч нь элсэлтийн ерөнхий шалгалтад 650-750 оноо авсан бол сургалтын төлбөрийн 70 хувийг, 751-ээс дээш оноо авсан бол 100 хувь
 - Нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 хүүхдийн төлбөрийн буцалтгүй тусламж олгоно.
- Амьжиргааны зардал олгох дэмжлэг
 - Багш бэлтгэдэг төрийн өмчийн их, дээд сургуулийн өдрийн ангид амжилттай суралцаж байгаа хөдөө, орон нутагт багшлах дадлага гүйцэтгэх суралцагчид тухайн сургуулийн нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийн 30 хувьтай тэнцэх хэмжээний амьжиргааны зардлыг олгоно.



5. Оюутан солилцоо

МУИС-ийн оюутнууд нь сургууль хоорондын хамтын ажиллагаа, оюутан солилцооны гэрээтэй гадаадын их дээд сургуульд нэг улирал эсвэл нэг хичээлийн жилийн хугацаанд оюутан солилцооны хөтөлбөрт хамрагдах боломжтой. Тус сургууль нь дэлхийн 250 гаруй их дээд сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй бөгөөд Япон, БНСУ, БНХАУ, Тайвань болон Европын 50 гаруй их сургуультай оюутан солилцооны хөтөлбөрийг идэвхтэй хэрэгжүүлдэг. 2016-2017 оны хичээлийн жилд МУИС-д 379 гадаадын оюутан суралцаж байгаа бөгөөд дипломын хөтөлбөрт 90, бакалаврын хөтөлбөрт 155, магистрын хөтөлбөрт 94, докторын хөтөлбөрт 44 оюутан суралцаж байна.

6. Соёл, спорт, эрүүл мэндийн үйлчилгээ

МУИС-ийн нийт суралцагсдад төлөвших, авьяас чадвараа нээн хөгжүүлэх, ажил амьдралын дадал эзэмших боломжийг олгох зорилгоор оюутанд чиглэсэн соёл, чөлөөт цагийн үйл ажиллагааг дараах үндсэн чиглэлүүдээр зохион байгуулдаг.

- Соёл урлагийн хөтөлбөр
- Спортын хөтөлбөр
- Эрүүл мэндийн хөтөлбөр
- Оюутны нийгэмд тустай үйл ажиллагааны хөтөлбөр
- Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн оюутны сайн дурын үйл ажиллагааны хөтөлбөр
- Хувь хүний хөгжлийг дэмжих хөтөлбөр
- Оюутны байгууллага, сайн дурын клубүүдийн үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр
- Оюутны амралт, чөлөөт цагийн хөтөлбөр

7. Хөгжлийн бэрхшээлтэй оюутнуудыг дэмжих үйлчилгээ

Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын суралцах боломж, орчин нөхцөлийг бүрдүүлэх, тэдэнд дэмжлэг үзүүлэх зорилтыг тавин ажиллаж байна.



Монгол Улсын Их Сургууль:

- <https://www.facebook.com/MUIS1942/>
 - <https://www.Facebook.com/Elselft.NUM>
 - [https://www.facebook.com/MUIS-Сургалтын нэгдсэн алба](https://www.facebook.com/MUIS-Сургалтын-нэгдсэн-алба)
 - https://twitter.com/num_edu
-

МУИС-ийн Сургалтын Нэгдсэн Алба:

- Хичээлийн I байр, 203 тоот
 - 77307730-(1122), (1123), (1129)
 - [www.Facebook.com/ Муис Сургалтын Нэгдсэн Алба](http://www.Facebook.com/Муис-Сургалтын-Нэгдсэн-Алба)
-

Мэдээллийн Технологийн Алба:

- Хичээлийн V байр, 501 тоот
 - 77307730-(1153), (1151)
-

Шинжлэх ухааны сургуулийн байгалийн ухааны салбар

- Хичээлийн II байр, 216 тоот
 - 77307730-(2103), (2105), (2108)
-

Шинжлэх ухааны сургуулийн нийгмийн ухааны салбар

- Хичээлийн II байр, 216 тоот
 - 77307730-(2103), (2105), (2108)
-

Шинжлэх ухааны сургуулийн хүмүүнлэгийн ухааны салбар

- Хичээлийн II байр, 216 тоот
 - 77307730-(2103), (2105), (2108)
-

Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль

- МУИС-ийн хичээлийн IIIa байр 212 тоот
 - 77307730-(3108), (3103)
-

Бизнесийн сургууль

- МУИС-ийн хичээлийн IV байр 203 тоот
 - 77307730-(4104), (4106)
-

Хууль зүйн сургууль

- МУИС-ийн хичээлийн IIIb байр 206 тоот
 - 77307730-(3503), (3518) 31-26-00
-

Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль

- МУИС-ийн хичээлийн V байр 201 тоот
 - 77307730-(5103), (5107), 354618
-

Орхон сургууль

- Эрдэнэт хот дах салбар сургуулийн байр
 - 70353621, 70352851
-

Завхан сургууль

- Завхан аймаг дах салбар сургуулийн байр
 - 70462398, 70463949
-



14201 Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, Их сургуулийн гудамж 1,
Утас/Факс: (976-11) 320668, 77307730-1122

<http://www.num.edu.mn/>
<http://burtgel.num.edu.mn/>
[https://www.facebook.com/МУИС-Сургалтын нэгдсэн алба](https://www.facebook.com/МУИС-Сургалтын-нэгдсэн-алба)